



[www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn)

# ХУРИМТЛАЛ БА ХАДГАЛАМЖ

# ХУРИМТЛАЛЫН ЗОРИЛГО, ХУРИМТЛАЛ ҮҮСГЭХ АРГА

Бидний амьдралд урт ба богино хугацааны төлөвлөж болох болон төлөвлөж болохгүй бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлага гардаг.

Энэ үед хамгийн сонгодог арга нь мөнгөн хуримтлалаараа гэнэтийн мөнгөний хэрэгцээгээ хангах юм.



# ХУРИМТЛАЛ ҮҮСГЭХ АЛХМУУД



## 2. ХАДГАЛАМЖИЙН ТӨРӨЛ, ТҮҮНИЙ ДАВУУ БА СУЛ ТАЛ

Мөнгөө хадгалуулах эрсдэл багатай арга бол банкинд хадгалуулах юм. Хадгаламж нь хугацаатай болон хугацаагүй гэсэн үндсэн төрөлтэй байдаг.

### ХУГАЦААГҮЙ ХАДГАЛАМЖ



*Та мөнгөө богино хугацаанд ашиглахаар төсөвлөсөн эсвэл гэнэтийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн бол хугацаагүй хадгаламжийг сонговол ашигтай.*

#### **Харилцах данс**

Өдөр тутмын төлбөр тооцоо төлөхөд ашиглах хүүгүй эсвэл маш бага хүүтэй байдаг.

#### **Хугацаагүй хадгаламж**

Харилцах данстай ижил боловч хүүний хувьд өндөр байдаг. Одоогоор банкууд жилийн 6% хүртэл хүү санал болгож байгаа ба хүүний төлбөрийг жил бүрийн сүүлийн өдөр дансанд шилжүүлнэ. Нэг сул тал нь банк хадгаламжийн хүүгээ бууруулахад таны хадгаламжийн хүү буурна. Харин давуу тал нь банкны хүү нэмэгдвэл таны хүү мөн нэмэгдэнэ.

### ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ



*Та тодорхой зорилготойгоор хуримтлуулах, мөнгөний хэрэгцээгээ хугацааны хувьд төлөвлөх боломжтой бол хугацаатай хадгаламжийг сонговол ашигтай.*

#### **Тодорхой хугацаатай хадгаламж**

1,3,6,12 сар болон түүнээс дээш хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн банкууд санал болгодог. Энэ нь хугацаагүй хадгаламжтай харьцуулахад өндөр хүүтэй байдаг. Та нэмэлт хуримтлал хийх боломжтой. Хэрвээ танд гэнэтийн мөнгөний хэрэгцээ хадгаламжийн хугацаа дуусахаас өмнө гарвал та хугацаагүй хадгаламжаас ч бага хүү авна. Иймээс таны санхүүгийн төлөвлөлт чухал юм.

#### **Хадгаламжийн сертификат**

Энэ нь хугацаатай хадгаламжаас өндөр хүү төлдөг хатуу нөхцөлтэй бүтээгдэхүүний нэг юм. Өөрөөр хэлбэл, хадгаламжийн хугацааны дундуур орлого хийх ба хугацаанаас өмнө цуцлах боломжгүй байдаг. Харин мөнгөний хэрэгцээ гарсан бол бусдад шилжүүлэх, зарах, бэлэглэх замаар бэлэн мөнгө болгож болдог.

### 3. ХЭРХЭН ХАДГАЛАМЖТАЙ БОЛОХ ВЭ?

Мөрөөдөл, зорилгодоо хүрэхийн тулд хуримтлалын төлөвлөгөөгөө гаргаж түүнд тууштай, санхүүгийн сахилга баттай байх нь чухал. Жишээ:

2016 оны 1-р сар	Гарьдын гэр бүлийн өрхийн орлого сарын 2.0 сая төгрөг			
	Аав	Ээж	Дунд хүү	Отгон хүү
Хуримтлалын зорилго	Хүүгийн хурим		Компьютер	Унадаг дугуй
Ач холбогдол	1		2	3
Хуримтлалын хэмжээ	5000000		1000000	200000
Хуримтлалын хугацаа	10 сар		9 сар	6 сар
Хадгаламжийн төрөл	10 сарын хугацаатай хүүнээс хүү бодох хадгаламж		9 сарын хугацаатай хадгаламж	6 сарын хугацаатай хадгаламж
Хуримтлалын төлөвлөгөө	Өрхийн орлогынхоо 15%-ийг том хүүгийн хуримд, 5%-ийг 2 бага хүүгийн хэрэгцээнд зориулах.		Зуны амралтаараа ажиллаж төлбөрийн 50%-ийг өөрөө олох.	Тэмдэглэлт баяруудаар цугларсан мөнгөө мөнгөний гахайдаа хадгалах.

## 4. ХАДГАЛАМЖИЙН ХҮҮНИЙ ТООЦООЛОЛ

### Энгийн хадгаламж

Хадгалуулах мөнгөн дүн, хугацаа, хүүний хувийг ашиглан ирээдүйд өсөх мөнгөн хэмжээг тооцоолж болно.

$$\text{Хадгаламжийн дүн} = \text{Анхны мөнгөн дүн} * (1 + \text{хүү})^{\text{жил}}$$

**Жишээ нь:** 1 сая төгрөгийг, жилийн 12%-иар хадгалуулбал 3-н жилийн дараа хэдэн төгрөгтэй болох вэ?

$$\text{Хадгаламж} = 1000000 * (1 + 0,12)^3 = 1404928 \text{ төгрөг}$$

### Хүүнээс хүү бодох хадгаламж

Банкууд энэ төрлийн хадгаламжийг хүүгээр арвижих хугацаатай хадгаламж, хуримтлалын хадгаламж гэх мэтээр нэрлэдэг.

Өмнөх жишээгээр сар бүр хүүнээс хүү тооцдог хадгаламжийн дүнг бодож үзье.

$$\text{Хадгаламжийн дүн} = \text{Анхны мөнгөн дүн} * \left(1 + \frac{\text{жилийн хүү}}{12}\right)^{\text{жил} * 12}$$

$$\text{Хадгаламж} = 1000000 * (1 + 0,12/12)^{3*12} = 1430768.78 \text{ төгрөг}$$

### Сар бүр тодорхой дүнгээр тогтмол дүнгээр хуримтлал үүсгэх хадгаламж

Тухайлбал, сар бүр 100000 төгрөгийн хуримтлалыг, жилийн 12%-ийн хүүтэй хадгална гэж үзвэл, 3 жилийн дараа хичнээн хэмжээний хуримтлалтай болсон байхыг бодъё.

$$\text{Хадгаламжийн дүн} = \text{Сар бүрийн хуримтлалын дүн} * \frac{(1 + \text{жилийн хүү}/12)^{\text{жил} * 12} - 1}{\text{жилийн хүү}/12}$$

$$\text{Хадгаламж} = 100000 * \frac{(1 + 0,12/12)^{3*12} - 1}{0,12/12} = 4307687.84 \text{ төгрөг}$$

# ХАДГАЛАМЖИД ҮЗҮҮЛЭХ ИНФЛЯЦИЙН НӨЛӨӨЛӨЛ

Инфляци хэдий чинээ их байна, хадгаламжийн хүүнээс олох орлогыг бууруулж байдаг.

❖ Хадгаламжийн бодит хүү = Хадгаламжийн нэрлэсэн хүү - Инфляцийн хувь

*Бодит хүүний тооцоолол /2013-2015 он/*

Он	Бодит хүү	
2013	-6,5% = 6% - 12,5%	Энэ үед хадгаламжийн хүү инфляциас бага байх тул таны хадгалуулж буй мөнгө 6.5%-иар үнэ цэнэ нь буурч байна. Өөрөөр хэлбэл, энэ үед та бусад хэлбэрийн үнийн өсөлттэй байгаа зүйл хөрөнгө оруулах эсэхээ шийдэх хэрэгтэй. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгө худалдан авах гэх мэт
2014	-5% = 6% - 11%	2013 онтой харьцуулахад арай дээр боловч мөнгөн хөрөнгө маань 5%-иар үнэ цэнээ алдахаар байна. Магадгүй бэлэн мөнгөөр гэртээ хадгалсан бол таны мөнгөний үнэ цэнэ 11%-иар буурах байлаа.
2015	4,1% = 6% - 1,9%	Таны хадгалуулсан мөнгө 4,1% өсөлттэй байхаар байна.

Бодит хүү гэдгийг инфляцийн нөлөөллийг тооцсон хүү гэж ойлгож болно.



**Баярлалаа**